

## ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны ... дугаар сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

"Монгол Улсын Засгийн газрын тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, "Автотээврийн тухай" хуулийн 17<sup>1</sup>дүгээр зүйлийн 17<sup>1.2</sup> дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ыг нэгдүгээр, "Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдэх мэдээллүүдийн жагсаалт"-ыг хоёрдугаар, "Автотээврийн хэрэгслийн цахим гэрчилгээний загвар"-ыг гуравдугаар, "Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ"-ний загварыг дөрөвдүгээр, "Бүрдүүлэх нийтлэг баримт бичгийн жагсаалт"-ыг тавдугаар, "Мопед, скүүтер бүртгэгдэх мэдээллийн жагсаалт"-ыг зургаадугаар, "Хасалтын тодорхойлолт"-ын загварыг долдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн бодлого, зохицуулалтын газар /Э.Мөнхнасан/, "Автотээврийн үндэсний төв" аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газар /Ц.Батсайхан/, "Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв" олон нийтийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2020 оны А/222 дугаар тушаал, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2021 оны А/136 дугаар тушаал, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2023 оны А/140 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Оюунтуяа/-т даалгасугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

оны ... дугаар тушаалаар батлагдсан  
“Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
хөтлөх, улсын дугаар олгох  
журам”-ын нэгдүгээр хавсралт

## **АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсад автотээврийн хэрэгслийг бүртгэх, улсын бүртгэлийн дугаар олгох, шилжилт хөдөлгөөн хийх, бүртгэлээс хасах, тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн сан хөтлөхтэй холбоотой харилцаанд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх ажлын зориулалтаар ашиглаж байгаа болон Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан албан тушаалтан, иргэн, Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэргийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь энэхүү журамд хамаарахгүй.

1.3. Автотээврийн хэрэгслийг бүртгэхдээ “Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт” MNS ISO 3833:2010 стандарт, “Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025 стандартыг тус тус баримтална.

### **Хоёр. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа**

2.1. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгслийн өмчлөх эрхийн болон ашиглалттай холбоотой бүртгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу өмчлөгчийн харьяаллын дагуу хөтөлнө. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна.

- 2.1.1. автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэх;
- 2.1.2. автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний бүртгэл;
- 2.1.3. автотээврийн хэрэгслийн техникийн болон өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл, засвар өөрчлөлтийн бүртгэл;
- 2.1.4. автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээ нөхөн олгох;
- 2.1.5. автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын өөрчлөлт, солилт, хадгалалт;
- 2.1.6. автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох;
- 2.1.7. автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах;
- 2.1.8. автотээврийн хэрэгслийн бүртгэлийг сэргээх;
- 2.1.9. автотээврийн хэрэгслийн бүртгэлийн архив.

### **Гурав. Автотээврийн хэрэгслийг бүртгэх, улсын бүртгэлийн дугаар олгох**

3.1. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өмчлөгчийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу хариуцсан бүртгэлийн байгууллага олгоно.

3.2. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. Ерөнхий шаардлага. MNS 4410 стандартад заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөл, эзэмшил, овор хэмжээ, ангилалд тохирох улсын бүртгэлийн дугаар болон дугаарын тэмдгийг олгоно.

3.3. Бүртгэлийн байгууллага нь үйлдвэрлэл, олборлолтын зориулалт бүхий олон улс, улс, орон нутаг, тусгай зориулалтын авто замаар зорчихгүй “Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025 стандартад заасан хэмжээнээс

хэтэрсэн даац, овор хэмжээ /урт, өргөн/-тэй тусгай тээврийн хэрэгслийн өмчлөл, эзэмшлийн талаарх бүртгэлийг мэдээллийн санд хөтөлнө. Эдгээр тээврийн хэрэгсэлд улсын бүртгэлийн дугаарын тэмдэг олгохгүй бөгөөд өмчлөгч, эсхүл эзэмшигчийн хүсэлтээр зөвхөн өмчлөл болон эзэмшлийн бүртгэлийн гэрчилгээг олгож болно.

3.4. Олон улсын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх бүх жин нь 10 тн-оос дээш ачааны автомашин болон 20-оос дээш хүний суудалтай нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн автобусанд “НАА” серийн улсын бүртгэлийн дугаар олгоно.

3.5. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ нь Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. Ерөнхий шаардлага. MNS 4410 стандартад заасны дагуу “энгийн”, “эко”, “нийтийн зорчигч тээвэр”, “дипломат”, “технологийн”, “төрийн өмчийн” гэсэн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр өнгийг бичих талбартай байна.

3.6. Автотээврийн хэрэгслийг төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглаж эхлэх болон хасагдах тохиолдолд эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг үндэслэн улсын бүртгэлийн дугаарын сери болон тоог өөрчлөхгүйгээр зөвхөн дэвсгэр өнгийг өөрчлөн сольж олгоно.

3.7. Үнэ хаялцуулах ажиллагааны ялагчтай байгуулсан гэрээ, улсын бүртгэлийн дугаарын захиалгыг үндэслэн зөвхөн түүний өмчлөлийн/эзэмшлийн тээврийн хэрэгсэлд тухайн дугаарыг олгоно.

3.8. Банк болон банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан улсын бүртгэлд бүртгүүлэх тохиолдолд эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу улсын бүртгэлийн дугаар олгоно.

### **Дөрөв. Автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэх**

4.1. Импортоор оруулж ирсэн болон Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийг Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэнэ.

4.2. Шинээр бүртгэсэн автотээврийн хэрэгсэлд улсын бүртгэлийн дугаар, цахим болон цаасан гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаарын тэмдэг олгоно.

4.3. Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэхэд хавсралтад заасан Бүрдүүлэх нийтлэг баримт бичгийг бүрдүүлнэ.

4.4. Бүрдүүлэх нийтлэг баримт бичгийн 5-д заасныг үрэгдүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагаас авсан хуулбар лавлагаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулж хүчингүй болсон тухай, бүртгэлийн байгууллагын цахим мэдээллийн хэрэгслээр хүчингүй болгосон тухай баримт бичгийг тус тус үндэслэн бүртгэнэ.

4.5. Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах болон буцах горимоор орж ирсэн тээврийн хэрэгслийг горим үйлчлэх хугацаанд бусдад шилжүүлэхгүй ба бүртгэлийн мэргэжилтэн тусгай тэмдэглэл хөтөлнө.

4.6. Автотээврийн хэрэгслийн техникийн үзүүлэлтийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад дурдсан жагсаалтын дагуу Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэлд үндэслэн мэдээллийн санд бүртгэнэ.

## **Тав. Автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний бүртгэл**

5.1. Шилжүүлж буй өмчлөгчөөс олгосон эрх, түүний ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэнэ.

5.2. Автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг өмчлөгч тоон гарын үсэг ашиглан цахимаар хийсэн тохиолдолд шилжүүлэн авч байгаа иргэн, хуулийн этгээд 24 цагийн дотор баталгаажуулна. Заасан хугацаанд өөрийн нэр дээр баталгаажуулж шилжүүлээгүй тохиолдолд тухайн бүртгэлийн үйлчилгээ цуцлагдах ба гарсан аливаа асуудлыг иргэн, хуулийн этгээд бүрэн хариуцна.

5.3. Дипломат байгууллагын тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг гаалийн бүртгэлийн маягыг дахин бүрдүүлж, холбогдох татвар төлөгдсөний дараа хийнэ.

5.4. Монгол улсын иргэн, хуулийн этгээд автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг Бүрдүүлэх нийтлэг баримт бичгээс гадна дараах баримт бичгийг үндэслэн шинэчлэн бүртгүүлнэ. Үүнд:

5.4.1. шилжүүлэн авсан болон шилжүүлэн өгсөн байгууллагын хүсэлт;

5.4.2. Автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг өмчлөх эрхийг шилжүүлсэн тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр;

5.4.3. Хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэр болон улсын бүртгэлийн байгууллагын тодорхойлолт.

5.5 Автотээврийн хэрэгслийн өмчлөгч иргэн нас барсан тохиолдолд өвлөх эрхийн гэрчилгээг үндэслэн өв нээгдсэн өдрөөс хойш 1 жилийн дотор өвлөгчийн нэр дээр шилжүүлэн бүртгэнэ.

5.6. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автотээврийн хэрэгслийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан, цуцалсан, өмчлөх эрхийг баталгаажуулсан, барьцааны гэрээ, мэдэгдлээр барьцаанд бүртгэсэн бол уг шийдвэрийг үндэслэн мэдээллийн санд оруулна.

5.7. Монгол Улсын Иргэний хуулийн дагуу өмчлөх эрх шилжүүлэх гэрээ байгуулагдсаны дараа тээврийн хэрэгслийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд тухайн гэрээнд заасан өмчлөгчийн нэр дээр шилжүүлэн бүртгэнэ.

5.8. Автотээврийн хэрэгслийн албан татвар, хуулиар оногдуулсан торгууль, олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөрийг тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч иргэний бүртгэлийн дугаар болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн дугаараар шалгана.

5.9. Банк бус санхүүгийн байгууллагын өмчлөлөөс эзэмшигчийн нэр дээр шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд тухайн эцсийн өмчлөгчийн харьяаллын дагуу улсын бүртгэлийн дугаарыг олгох, бүртгэлийн мэргэжилтэн улсын бүртгэлийн дугаарыг өмчлөгчийн засаг, захиргаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу болгох үүрэг хүлээнэ.

### **Зургаа. Автотээврийн хэрэгслийн өмчлөгчийн болон техникийн мэдээлэл, засвар өөрчлөлтийн бүртгэл**

6.1. Автотээврийн хэрэгслийн өмчлөгчийн болон техникийн мэдээлэл, засвар өөрчлөлтийн бүртгэлд дараах мэдээлэл хамаарна. Үүнд:

6.1.1. автотээврийн хэрэгслийн зориулалтын өөрчлөлт;

6.1.2. өнгөний өөрчлөлт;

6.1.3. хөдөлгүүр солих;

6.1.4. өмчлөгчийн хүсэлтээр эзэмшигчийн мэдээлэл.

6.2. Тухайн автотээврийн хэрэгслийн зориулалтыг зөвхөн үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр өөрчлөх ба үйлдвэрлэгчээс эрх олгогдсон авто үйлчилгээний байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

6.3. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өмчлөгчийн болон эзэмшигчийн техникийн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт хавсаргана.

6.4. Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй, алдаатай бүртгэгдсэн мэдээллийг архивын болон бусад холбогдох баримт бичиг үндэслэн мэдээллийг өөрчилнө.

#### **Долоо. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээ нөхөн олгох**

7.1. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын бүртгэлийн дугаарыг хаяж, үрэгдүүлсэн болон цаашид ашиглах боломжгүй болсон тохиолдолд өмчлөгчийн хүсэлтээр нөхөн олгоно.

7.2. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автотээврийн хэрэгслийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан тохиолдолд шийдвэр гаргасан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн нөхөх олгоно.

#### **Найм. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын өөрчлөлт, солилт, хадгалалт**

8.1. Өмчлөгчийн хүсэлтээр улсын бүртгэлийн дугаарыг дараах тохиолдолд өөрчилж, солино.  
Үүнд:

8.1.1. улсын дугаарын хязгаарлалтаас хамаарч гарагийн өөрчлөлт;

8.1.2. худалдан авсан улсын бүртгэлийн дугаараар;

8.1.3. өрхийн нэг гэр бүлийн гишүүд хооронд улсын бүртгэлийн дугаараа солих.

8.2. Улсын бүртгэлийн дугаарыг өөрчилж, сольсон тохиолдолд өмчлөгч хүсэлт гаргаагүй бол өмнөх улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг заавал хураан авч, устгалд оруулна.

8.3. Бүртгэлийн байгууллагад улсын бүртгэлийн дугаараа хураалгаагүй тохиолдолд гарах аливаа асуудлыг холбогдох хуулийн хүрээнд өмчлөгч өөрөө хариуцна.

8.4. Улсын бүртгэлийн дугаарыг өмчлөгчийн хүсэлтээр тухайн оршин суух засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяаллын дагуу сольж, өөрчилнө.

8.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автотээврийн хэрэгслийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан тохиолдолд улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөх, солих бүртгэл хийгдэхгүй.

8.6. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг хадгалах хугацаа 1 удаад 120 хоног хүртэл байх ба хугацааг дахин сунгаж болно. Хадгалсан дугаарыг худалдах, бэлэглэх, барьцаалах замаар бусдад шилжүүлж болно.

8.7. Автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч автотээврийн хэрэгслийг орон нутгийн бүртгэлд бүртгүүлсэн эсхүл ашиглалтаас хасуулсан бол автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өөр автотээврийн хэрэгсэлд ашиглаж болно.

8.8. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын давхацлыг архивын баримт бичгийг үндэслэн олгосон огнооны дагуу шийдвэрлэнэ.

### **Ес. Автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох**

9.1. “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002<sup>1</sup> стандартын D хавсралтын 4 дэх зурагт заасан загварын хүрээнд түр дугаарыг дараах тохиолдолд олгоно.

9.1.1. экспортод гаргах зорилгоор автотээврийн хэрэгслийн бүртгэлээс хасагдсан тээврийн хэрэгсэлд;

9.1.2. автотээврийн хэрэгсэл худалдаалах албан ёсны эрх бүхий байгууллагын худалдан борлуулахаар импортоор оруулж ирсэн автотээврийн хэрэгсэлд иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэгт үндэслэн үзэсгэлэн худалдаанд оролцох зорилгоор авто замын хөдөлгөөнд оролцох үед;

9.1.3. Эрх бүхий байгууллагын хүсэлтээр Аялал жуулчлалын зорилгоор аялах үед.

9.1.4. барааг түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенцийн хавсралт А-д заагдсан АТА, СРТ карнейг үндэслэн түр дугаар олгохдоо холбогдох Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд хугацааг тогтооно.

9.2. Техникийн хяналтын үзлэгт тэнцсэн байна.

9.3. Экспортод гаргах зорилгоор автотээврийн хэрэгслийн бүртгэлээс хасагдсан тээврийн хэрэгсэлд олгох түр дугаарын үйлчлэх хугацаа 72 цагаас хэтрэхгүй ба хасалтын тодорхойлолт хамт олгоно;

9.4. Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дах заалтын дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч Жолоочийн даатгалд даатгуулна.

9.5. Импортоор орж ирсэн автотээврийн хэрэгслийг Автотээврийн тухай хуулийн 17<sup>11</sup> дэх хэсэгт заасан хугацаанд гаалийн хяналтын талбайгаас өмчлөгчийн хүсэлт гаргасан байршил хүртэл гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг үндэслэн түр дугаар авч, авто замын хөдөлгөөнд оролцоно.

9.6. Албан ёсны эрх бүхий байгууллагын хүсэлт, гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон хуулбарыг үндэслэн түр дугаарыг олгоно.

9.7. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох зохицуулалтыг Замын хөдөлгөөний тухай конвенцийн дагуу шийдвэрлэнэ.

9.8. Замын хөдөлгөөний тухай конвенцид нэгдэн ороогүй улсын автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох асуудлыг Засгийн газрын хооронд байгуулсан автотээврийн хэлэлцээрийн дагуу шийдвэрлэнэ.

9.9. Түр дугаарыг “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002<sup>1</sup> стандартын D хавсралтын 4 дэх зургийн “Transit” гэдгийн оронд

албан ёсны борлуулагчийн нэр, “дугаарын оронд автотээврийн хэрэгслийн арлын дугаарыг бичиж олгоно.

### **Арав. Автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах**

10.1. Автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасахад дараах тээврийн хэрэгсэл хамрагдана.  
Үүнд:

10.1.1. ашиглах боломжгүй болсон, өмчлөгчийн хүсэлтээр хасагдах тээврийн хэрэгсэл;

10.1.2. Монгол Улсад ашиглагдаж байгаад экспортод гарсан автотээврийн хэрэгсэл;

10.2. Бүртгэлийн байгууллага автотээврийн хэрэгслийг дараах тохиолдолд бүртгэлээс түр хасна. Үүнд:

10.2.1. эрх бүхий хуулийн байгууллагын шийдвэр гарсан байх;

10.2.2. тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч тогтоогдохгүй байх;

10.2.3. сүүлийн 3 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй;

10.2.4. тээврийн хэрэгсэл өмчлөгчийн зүгээс энэхүү журмын Тавдугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд

10.3. Барьцаанд бүртгүүлсэн автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, хасалт, сэргээх зэрэг бүртгэлийн үйлчилгээ хийхгүй.

10.4. Автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулахад иргэн, хуулийн этгээд Бүрдүүлэх нийтлэг баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

10.4.1. *улсын дугаарын тэмдэг үрэгдүүлсэн бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт;*

10.4.2. *автотээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрт тушаасан бол тухайн үйлдвэрийн тодорхойлолт;*

10.4.3. хэрэв автотээврийн хэрэгслийг улсын хилээр гаргасан бол гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг

10.5. Бүртгэлийн мэргэжилтэн нь хүсэлт, бүрдүүлсэн баримт бичгийг үндэслэн бүртгэлээс хасагдсан автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг хураан авч, мэдээллийн санд бүртгэн, хасалтын тодорхойлолтыг өмчлөгчид олгоно.

### **Арван нэг. Автотээврийн хэрэгслийн бүртгэл сэргээх**

11.1. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийг дараах тохиолдолд нэг удаа сэргээнэ. Үүнд:

11.1.1. Бүртгэлийн байгууллага хассан тохиолдолд тээврийн хэрэгслийн бүртгэлийг сэргээнэ.

11.1.2. өмчлөгч зөрчлөө арилгасны дараа тухайн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийг буцаан сэргээнэ;

11.1.3. Мэдээллийн санд бүртгэл хийгдээгүй байгаа тээврийн хэрэгслийг архивын баримтыг үндэслэн бүртгэнэ.

11.2. Хасагдсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг сэргээхэд Бүрдүүлэх нийтлэг баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

11.2.1. хүсэлт;

11.2.2. иргэн, хуулийн этгээдийн үнэмлэх, гэрчилгээний хуулбар;

- 11.2.3. тээврийн хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан тухай техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт;
- 11.2.4. автотээврийн хэрэгслийн гэрчилгээг хаяж гээгдүүлсэн тохиолдолд хүчингүй болгосон тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт

#### **Арванхоёр. Автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах**

- 12.1. Дараах тохиолдолд автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана. Үүнд:
- 12.1.1. баримт бичиг нь бүрэн бус, мэдээлэл зөрүүтэй, засварласан;
  - 12.1.2. техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тэнцээгүй;
  - 12.1.3. автотээврийн хэрэгслийн албан татвар төлөөгүй байх;
  - 12.1.4. хуулийн дагуу оногдуулсан торгууль болон олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөр төлж барагдуулаагүй;
  - 12.1.5. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй зориулалтыг өөрчилсөн;
  - 12.1.6. шилжүүлж буй өмчлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч биечлэн ирээгүй;
  - 12.1.7. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ, үйлчилгээний төлбөр төлөөгүй;
  - 12.1.8. эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт хийсэн;
  - 12.1.9. Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй.
  - 12.1.10. хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэгт “сэлбэг”, “бүхээг” гэж бичигдсэн тохиолдолд улсын бүртгэлийн дугаар олгохоос татгалзана.
- 12.2. Бүртгэлийн мэргэжилтэн нь тухайн автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэлийг тодорхой тайлбарлан хүсэлтэд тэмдэглэж, гарын үсэг зурж хувийн дугаар бүхий тэмдэг дарна.
- 12.3. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж байгаа транзит тээвэрт олгосон НАА серийн дугаарыг бусдад шилжүүлэх, солих үйлчилгээг бүртгэхээс татгалзана.

#### **Арвангурав. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн архив**

- 13.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 16.2 дах заалтын дагуу Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн архив нь төрөлжсөн архивын төрөлд хамаарна.
- 13.2. Бүртгэлийн байгууллага нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох нийтлэг журмыг баримтлан Архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллана.
- 13.3. Өмчлөгчийн хүсэлтээр автотээврийн хэрэгслийн архивын лавлагаа, үйлчилгээг үзүүлнэ.
- 13.4. Бүртгэлийн байгууллага автотээврийн хэрэгслийн бүртгэлийн цахим архивыг тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд 48 цагийн дотор оруулах үүрэгтэй.

#### **Арвандөрөв. Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн бүртгэл**

- 14.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12<sup>1</sup>.4 дэх заалтын дагуу Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн хавсралт 6-д заасан мэдээллийг бүртгэж, 1 үсэг, 5 тоо бүхий бүртгэлийн дугаар олгоно.

14.2. Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдлыг өмчлөгч хариуцна.

14.4. Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах боломжгүй болсон тохиолдолд өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн бүртгэлээс хасна.

### **Арвантав. Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх болон цахим үйлчилгээ**

15.1. Мэдээллийн сан нь бүртгэлийн эх баримт бичиг бүхий архив, цахим мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохицуулсан журам, зааврыг мөрдлөг болгоно.

15.2. Мэдээллийн сан нь төрийн үйлчилгээний болон зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн сантай холбогдож, энэхүү журмын 15.1 дэх заалтын хүрээнд харилцан мэдээлэл солилцох нөхцөл, бололцоо бүрдүүлсэн байна.

15.3. Автотээврийн хэрэгслийн талаар бусад төрийн байгууллагуудаас авах мэдээллүүдийг бүртгэлийн байгууллага баримт бичиг шаардахгүй ба төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох журмын хүрээнд цахим сүлжээгээр дамжуулан мэдээллийг авч архивлана.

15.4. Үйлчлүүлэгч нь төрийн нэгдсэн үйлчилгээний системээр болон бүртгэлийн байгууллагын цахим системээр дамжуулан цахим үйлчилгээг авна.

15.5. Үйлчлүүлэгч нь өөр хоорондоо “Цахим гарын үсгийн тухай” хуулийн дагуу тоон гарын үсгээр баталгаажуулсан хэлцлийн дагуу бүртгэлийн байгууллага нь цахимаар бүртгэл хийнэ.

15.6. Цахимаар үйлчлүүлэгчид автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаарын тэмдэгтийг шуудангаар, эсхүл угтах үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчид хүргэж болно. Шуудангаар хүргүүлсэн тохиолдолд тухайн үйлчилгээнд мөрдөж байгаа үнэ тариф нэмэгдэж тооцогдоно.

15.7. Мэдээллийн санд автотээврийн хэрэгслийн марк, загвар, хөдөлгүүр, арлын болон цахим гэрчилгээ (RFID, Smart ID, OTP, FIDO...гэх зэрэг)-ний дугаарыг латин үсгээр, бусад мэдээллийг кирилл үсгээр бүртгэнэ.

15.8. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахим болон цаасан хэлбэрээр олгоно. Гэрчилгээ нь монгол, англи хэл дээр байх ба өмчлөгчийн хүсэлтээр цаасан гэрчилгээг хэвлэнэ.

### **Арванзургаа. Бүртгэлийн байгууллагын баримтлах зарчим**

16.1. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан нийтлэг чиг үүргийг автотээврийн хэрэгслийн бүртгэл хариуцсан байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

16.2. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгслийн өмчлөгчийн харьяаллын дагуу энэхүү журамд заасан бүртгэл хөтөлж, статистик мэдээ, тайлан гаргах, өмчлөгчтэй холбоотой лавлагаа, мэдээлэл өгөх ажлыг хариуцан гүйцэтгэх ба тайлан мэдээг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг тухай бүр мэдээллээр хангана.

16.3. Сайдаас эрх олгосны дагуу ажил хариуцуулан гүйцэтгүүлэх тухай гэрээнд бүртгэлийн байгууллагын эрх, үүргийн талаар тодорхой тусгасан байна.

16.4. Сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах замаар худалдан борлуулах улсын бүртгэлийн дугаарын жагсаалтыг бүртгэлийн байгууллага эрэмбэлэн мэдээллийн санд байршуулж, худалдан борлуулна.

16.5. Үнэ хаялцуулах ажиллагааг Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн холбогдох заалтыг үндэслэн бүртгэлийн байгууллага бусад байгууллагатай хамтран цахим хэлбэрээр зохион байгуулна.

16.6. Үнэ хаялцуулах ажиллагаагаар төвлөрүүлсэн орлогоос үйл ажиллагааны зардлыг тооцон суутгаж холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай санд төвлөрүүлнэ.

16.7. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг нийтэд нээлттэй ил тод зохион байгуулж, иргэн, хуулийн этгээд улсын бүртгэлийн дугаарыг сонгон захиалах боломжоор хангасан байна.

16.8. Улсын бүртгэлийн дугаар нь иргэд, олон нийтэд ил тод харагдах бөгөөд улсын дугаар захиалга өгсөн (жагсаалтад орсон) иргэн хуулийн этгээдийн захиалга өгсөн мэдээлэл ил тод нээлттэй байна.

16.9. Цахим хүсэлт нь Цахим гарын үсгийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд иргэн, хуулийн этгээдийн санаатай болон санамсаргүй байдлаас үүссэн аливаа эрсдэлийг бүртгэлийн байгууллага хариуцахгүй болно.

16.10. Бүртгэлийн мэргэжилтэн нь Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан нийтлэг эрх, үүргийг хүлээх бөгөөд ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан заасан байна.

16.11. Бүртгэлийн мэргэжилтэн нь автотээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой мэдээлэлд албан бус хайлт хийх, ашиглах, төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

16.12. Бүртгэлийн мэргэжилтэн нь Үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээд бүртгэлийн байгууллагад хандсан тохиолдолд автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгох, захиалах, хадгалах, гэрчилгээ солилт, нөхөлт, хасалтын үйлчилгээг хийнэ.

#### **Арвандолоо. Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэгийн үйлдвэр бүртгэлийн дугаарын тэмдэг олгоход тавигдах шаардлага**

17.1. “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 1-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS4410-1:2002<sup>1</sup> стандартын шаардлага бүрэн хангасан тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг үйлдвэрлэнэ;

17.2. “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 1-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS4410-1:2002<sup>1</sup> стандартад заагаагүй өнгө, тэмдэглэгээ бүхий улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэхгүй байх;

17.3. Тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн ([www.vrs.transdep.mn](http://www.vrs.transdep.mn)) системд холбогдож, шинээр болон нөхөн олгох улсын дугаарын мэдээллийг тухай бүр шивж оруулдаг байх, мөн цахим мэдээллийг үндэслэн улсын дугаар хэвлэж олгодог байх;

17.4. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаарын ар талд тухайн компаний зориулалтын дардасыг тогтмол дарж хэвших;

### **Арваннайм. Бусад зүйл**

18.1. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

18.2. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, бүртгэлийн мэдүүлэг, экспортын сертификатын загварыг батлах, хэвлүүлэх, хадгалах, зарцуулах үйл ажиллагаанд автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

18.3. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

Зам, тээврийн сайдын 2026  
оны ... дугаар тушаалаар батлагдсан  
“Автотээврийн хэрэгслийн бүртгэл

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНД  
БҮРТГЭГДЭХ МЭДЭЭЛЛҮҮДИЙН ЖАГСААЛТ**

- 1.Марк
- 2.Загвар
- 3.Үйлдвэрлэсэн улс
- 4.Үйлдвэрлэсэн огноо
- 5.Импортолсон огноо
- 6.Арлын дугаар /VIN дугаар/
- 7.Хөдөлгүүрийн дугаар
- 8.Өнгө
- 9.Бүх жин, кг
- 10.Даац, кг
- 11.Өөрийн жин, кг
- 12.Суудлын тоо
- 13.Хаалганы тоо
- 14.Оврын хэмжээ, мм, Урт /Өргөн/ Өндөр
- 15.Хүрдний байрлал
  - 15.1.баруун
  - 15.2.зүүн
- 16.Ангилал
  - 16.1.А ангилал
  - 16.2.В ангилал
  - 16.3.С ангилал
  - 16.4.Д ангилал
  - 16.5.Е ангилал
  - 16.6.М ангилал
- 17.Автотээврийн хэрэгслийн төрөл, зориулалт
  - 17.1.Суудлын автомашин /бүхээгийн хэлбэрээр/:
  - 17.2.Автобус
    - 17.2.1.угсраа автобус
    - 17.2.2.том оврын автобус
    - 17.2.3.дунд оврын автобус
    - 17.2.4.бага оврын автобус
    - 17.2.5.троллейбус
  - 17.3.Ачааны автомашин
    - 17.3.1.энгийн тэвштэй ачааны автомашин
    - 17.3.2.эмээлт зүтгүүр
    - 17.3.3.өөрөө буулгагч
  - 17.4.Тусгай зориулалтын ачааны автомашин
    - 17.4.1.автоцистерн нефтийн бүтээгдэхүүний
    - 17.4.2.сүүний
    - 17.4.3.усны
    - 17.4.4.бохирын цооногийн
    - 17.4.5.барилгын зуурмаг тээвэрлэгч
    - 17.4.6.барилгын зуурмаг шахагч

- 17.4.7.автокран
- 17.4.8.техникийн түргэн тусламжийн
- 17.4.9.эмнэлгийн түргэн тусламжийн
- 17.4.10.гал командын
- 17.4.11.ахуйн хог хаягдлын
- 17.4.12.хүнсний технологийн
- 17.4.13.бусад
- 17.5.Чиргүүл
- 17.5.1.ачааны автомашины
- 17.5.2.торхтой чиргүүл
- 17.5.3.суудлын автомашины
- 17.5.4.хагас чиргүүл
- 17.5.5.аяллын зориулалттай чиргүүл
- 17.5.6.хөргүүр, дулаан тохируулагч бүхий чиргүүл
- 17.6.Мотоцикл
- 17.6.1. 2 дугуйтай
- 17.6.2. 3 дугуйтай
- 17.6.3. 4 дугуйтай
- 17.6.4. Ачааны мотоцикл
- 17.7.Механизм
- 17.7.1.дугуйт трактор
- 17.7.2.өөрөө явагч дугуйт механизм
- 17.7.3.гинжит трактор
- 17.7.4.гинжит механизм
- 18.Хөдөлгүүрийн төрөл гэдэгт:**
- 18.1.бензин
- 18.2.дизель
- 18.3.хий дизель хосолсон
- 18.4.цахилгаан-бензин /Хосолсон /гибрид/
- 18.5.Хий
- 18.5.1.шингэрүүлсэн нефтийн хий /LPG/
- 18.5.2.байгалийн шахсан хий -/CNG/-
- 18.5.3.Шингэрүүлсэн байгалийн хий /LNG/
- 18.6. Бүрэн цахилгаан
- 18.6.1 Туулалтын зай уртасгагчтай /Бензин - Extended Range/**
- 18.7.Устөрөгчийн
- 18.8.Хөдөлгүүрийн багтаамж, см<sup>3</sup>
- 19.Экологийн ангилал
- 19.1.евро 0
- 19.2.евро I
- 19.3.евро II
- 19.4.евро III
- 19.5.евро IV
- 19.6.евро V
- 19.7.евро VI
- 19.8.бусад
- 20.Хурдны хайрцаг
- 20.1.механик
- 20.2.автомат

- 20.3.хосолсон/хагас автомат/
- 20.4.бусад
- 21.Насжилт /тайлангаар гаргах боломжтой байх/
- 22.Хөтлөгчийн төрөл
  - 22.1.урд хөтлөгчтэй,
  - 22.2.хойт хөтлөгчтэй,
  - 22.3.давхар хөтлөгчтэй,
- 23.Тэнхлэгийн тоо, /тоогоор/

“Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын гуравдугаар хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР





**МОНГОЛ УЛС**

**АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭ**

**Certificate of vehicle registration**

Дугаар .....

**Ургийн овог:**  
Family name:

**Овог:**  
Surname

**Нэр:**  
Given name

**Хаяг:**  
Address

**Утасны дугаар:**  
Phone number

РД: .....

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**  
Technical specification

1	Улсын дугаар <small>Registration plate number</small>		9	Аргын дугаар <small>Chassis number</small>
2	Марк <small>Make</small>		10	Хөдөлгүүрийн дугаар <small>Engine number</small>
3	Загвар <small>Model</small>		11	Үйлдвэрлэсэн он <small>Year of manufacture</small>
4	Ангилал, хөдөлгүүрийн багтаамж <small>Category, engine displacement</small>		12	Импортолсон өнөө <small>Date of importation</small>
5	Бүх жин <small>Gross vehicle weight</small>		13	Өнгө <small>Color</small>
6	Даац, суудлын тоо <small>Loading capacity, number of seats</small>		14	Улсын дугаарын дэвсгэр өнгө <small>Registration plates color</small>
7	Төрөл <small>Type</small>		15	Техникийн хяналтын үзлэг <small>Technical inspection</small>
8	Зориулалт <small>Vehicle designation</small>			

Жич: Цахим архивын лавлагаа нь архивын баримт, эх сурвалжид тулгуурлан гаргах хууль зүйн хүчин төгөлдөр, албан ёсны баримт мөн.



Олгосон байгууллагын нэр:  
Issuing authority:

Олгосон өгнөө:      он   сар   өдөр

Зам, тээврийн сайдын 2026 оны ... дугаар тушаалаар батлагдсан

“Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын дөрөвдүгээр хавсралт

### АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Technical specifications		MGL	ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА Certificate issuing authority
Улсын бүртгэлийн дугаар Registration plate number	Хөдөлгүүрийн дугаар Engine number		
Марк, загвар Make, model	Үйлдвэрлэсэн он Year of manufacture		
Алиман, хөдөлгүүрийн багтаамж Category, engine displacement	Импортолсон огноо Date of importation		Бүртгэлийн ажилтан Registration officer
Бүх жин Gross vehicle weight	Өнгө, Color		Тэмдэг Stamp
Даац, суудлын тоо Loading capacity, number of seats	Тэнхлэгийн тоо Axes		Гарын үсэг Signature
Төрөл Type	Улсын бүртгэлийн дугаарын өнгө Color registration plate number		.....Он.....сар.....өдөр .....YYYY.....MM.....DD
Зориулалт Vehicle designation	Өмчлөгч Owner		Тусгай тэмдэглэл additional note
VIN дугаар, VIN number			
Арлын дугаар, Chassis number	Хаяг Address		
Бүхээгийн дугаар, Cabin number			
		№ 00000000	

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ TECHNICAL INSPECTION			MGL	МОНГОЛ УЛС MONGOLIA
Он, Сар, Өдөр YYYY.MM.DD	Техникийн байдал Technical status	Гарын үсэг Тэмдэг signature Stamp	САНАМЖ	
			<p>АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧЛӨГЧ ТА:</p> <ul style="list-style-type: none"> <li>◆ Шинээр автотээврийн хэрэгсэл өмчилж авсан бол 72 цагийн дотор;</li> <li>◆ Ашиглалтаас хассан бол 1 сарын дотор;</li> <li>◆ Нэр, хаяг, арлын болон хөдөлгүүрийн дугаар, өнгө өөрчлөгдсөн бол 7 хоногийн дотор тус тус бүртгүүлэх;</li> <li>◆ Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдах;</li> <li>◆ Хуульд заасан хугацаанд албан татвараа төлөх;</li> <li>◆ Тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулах үүрэгтэй</li> </ul>	<p>CERTIFICAT D'IMMATRICULATION DU VEHICULE</p> <p>АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</p> <p>CERTIFICATE OF VEHICLE REGISTRATION</p> <p>MGL</p>
Засвартай бол хүчингүй Not valid if edited			№ 00000000	

Зам, тээврийн сайдын 2026

оны ... дугаар тушаалаар батлагдсан  
 “Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
 хөтлөх, улсын дугаар олгох  
 журам”-ын тавдугаар хавсралт

Бүрдүүлэх нийтлэг баримт бичиг

	Иргэн	Хуулийн этгээд
1	хүсэлт	хүсэлт
2	иргэний үнэмлэх, болон түүнтэй адилтгах цахим лавлагаа	хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон хуулбар;
3	Монгол Улсад байнга болон түр оршин суугч гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн гадаад паспорт, оршин суух үнэмлэх	гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүсэлт /Дипломат/
4	Гаалийн бүртгэлийн маягт /шинээр бүртгүүлэх, түр дугаар/	
5	Импортоор оруулж ирсэн шинэ болон ашиглагдаж байсан автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн, эсхүл экспортын дагалдах баримт бичиг,	
6	үйлдвэрээс тусгай тоноглол суурилагдсан автотээврийн хэрэгслийн хувьд нэмэлт төхөөрөмжийн техникийн байдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан дүгнэлт /шинээр бүртгүүлэхэд/	
7	Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийн хувьд тохирлын болон техникийн гэрчилгээ, автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар /VIN code/ олгосон тухай баталгаажуулсан баримт /шинээр бүртгүүлэхэд/	
8	Монгол Улсын Иргэний хуульд заасан өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ, нотариатаар гэрчлүүлсэн гэрээ	
9	техникийн хяналтын үзлэгт тэнцсэн байх /шинээр бүртгүүлэх, техникийн өөрчлөлт, бүртгэл сэргээх/	
10	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /улсын бүртгэлийн дугаар нөхөн олголт/	
11	автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ төлсөн баримт	
12	үйлчилгээний хөлс төлсөн баримт	
13	автотээврийн хэрэгслийн гэрчилгээ /гэрчилгээ нөхөн олголт, улсын бүртгэлийн дугаар өөрчлөлт, улсын дугаар захиалга, хадгалалт/	
14	хүчингүй болгосон тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт /улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээ нөхөн олголт/	

15	автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын өргүй байх /шилжилт хөдөлгөөн, хасалт, сэргээх/
16	хуулиар оногдуулсан торгууль
17	олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөр төлсөн баримт
18	архивын болон бусад холбогдох баримт бичиг /өөрчлөлт, засвар бүртгэл/
19	Барьцааны гэрээ, мэдэгдэл/хязгаарлалт/
20	Жолоочийн даатгалд даатгуулсан байх /шинээр бүртгүүлэх, түр дугаар/

---o0o---

Зам, тээврийн сайдын 2026  
оны ... дугаар тушаалаар батлагдсан  
“Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
хөтлөх, улсын дугаар олгох  
журам”-ын зургаадугаар хавсралт

**Мопед, скүүтер бүртгэгдэх  
мэдээллүүдийн жагсаалт**

1. Сериал дугаар
2. Марк нэр
3. Модел нэр
4. Үйлдвэрлэсэн улс
5. Үйлдвэрлэсэн он
6. Орж ирсэн он
7. Ангилал
8. Өнгө
9. Батерэйн чадал

Зам, тээврийн сайдын 2026  
оны ... дугаар тушаалаар батлагдсан  
“Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
хөтлөх, улсын дугаар олгох  
журам”-ын долдугаар хавсралт

### ХАСАЛТЫН ТОДОРХОЙЛОЛТ/ CERTIFICATE

Он /YYYY..... сар /MM..... өдөр/ DD..... № .....

УЛААНБААТАР/ULAANBAATAR

Тээврийн хэрэгслийн мэдээлэл/vehicle information	УД/RegistrationNo		Хөд.Багтаамж/Engine capacity	
	Марк.Модель/Make.Model		Өнгө/Colour	
	Арлын дугаар/Maker's serial number		Ө.жин/ weight	
	Хөд.дугаар/Engine number		Б.жин/Gross weight	
	Үйлд.он/Year		Суудлын тоо/Fixed Number	
	Зориулалт.төрөл/Purpose.Type		Шатахууны төрөл/Classification of fuel	
	Их биеийн төрөл/Type of body		Урт.Өргөн.Өндөр/ Length.Width.Height	
Өмчлөгчийн мэдээлэл/owner information	Овог/Surname		Нэр/Name	
	Хаяг/Address			
Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 7 дугаар бүлгийн заалтыг үндэслэн улсын бүртгэлээс хасав /This vehicle deregistrated from state vehicle registration, via section 7 of the vehicle registration rule/.				

Тодорхойлолт гаргасан:

Байгууллагын нэр, Албан тушаал, нэр, гарын үсэг